



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/606

Мөрөн сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/331 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум орон нутгийн хэмжээнд 2024 оны цэргийн бүртгэл зохион байгуулж явуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Цэргийн бүртгэлийг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд "Цэргийн бүртгэл явуулах журам"-ын дагуу зохион байгуулж, холбогдох мэдээ, судалгаа, тайланг үнэн зөв гаргаж, 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт ирүүлэхийг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Цэргийн бүртгэлтэй холбогдуулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар ханган ажиллаж, аймгийн нэгдсэн дүн, мэдээг тогтоосон хугацаанд гаргаж Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа С.Батхуяг)-д даалгасугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011405